



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2018 оны 10 сарын 19 өдөр

Дугаар А/429

Улаанбаатар хот

Төгсөлтийн дараах үндсэн мэргэшлийн сургалтын хяналтын тоог шинэчлэн батлах, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дах хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.9 дэх заалт, 25 дугаар зүйлийн 25.12 дах хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийн хэрэгцээ, төгсөлтийн дараахь сургалт явуулах байгууллагын хүчин чадлыг харгалзан Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/168 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "2018-2019 оны хичээлийн жилд эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах үндсэн мэргэшлээр суралцуулах хяналтын тоо"-г хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/186 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан улсын төсвийн санхүүжилтээр тэтгэлэгтэй суралцуулах хяналтын тооноос өрх судлалын 1 хяналтын тоог дүрс оношилгоо судлалын хяналтын тоонд, өрх судлалын 2 хяналтын тоог мэс засал судлалын хяналтын тоонд тус тус шилжүүлж, нийт 3 хяналтын тоог өөрчилсүгэй.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Д.Ганцэцэг/, төгсөлтийн дараах үндсэн мэргэшлийн сургалт эрхлэх байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.

4. Тушаалын 2 дах заалтын дагуу улсын төсвийн санхүүжилтээр орон нутгаас нэмж суралцах резидент эмч нартай гэрээ байгуулж, хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Д.Ганцэцэг/, төгсөлтийн дараах үндсэн мэргэшлийн сургалт эрхлэх байгууллагын дарга, захирал, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт тус тус үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн дарга /Э.Содномжамц/-д даалгасугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

Эрүүл мэндийн сайдын 2018 оны
10-р сарын 19 өдрийн А.М. дугаар
тушаалын хавсралт



"2018-2019 оны хичээлийн жилд эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах үндсэн мэргэшлээр суралцуулах хяналтын тоо"

№	Сургалтын чиглэл	Хяналтын тоо
1.	Нүүр амны гажиг судлал	20
2.	Нүүр амны мэс засал судлал	24
3.	Нүүр амны согог засал судлал	21
4.	Хүүхдийн нүүр ам судлал	10
5.	Шүдний ерөнхий эмчилгээ судлал	5
6.	Анатомын эмгэг судлал	15
7.	Арьс судлал	28
8.	Гэмтэл согог судлал	30
9.	Дотрын анагаах судлал	151
10.	Дүрс оношлогоо судлал	61
11.	Ерөнхий мэргэшил судлал	36
12.	Зоонозын өвчин судлал	13
13.	Мэдрэл судлал	40
14.	Мэдээгүйжүүлэг судлал	28
15.	Мэс засал судлал	68
16.	Нүд судлал	23
17.	Өрхийн анагаах судлал	25
18.	Сүрьеэ судлал	23
19.	Сэтгэц судлал	22
20.	Хавдар судлал	20
21.	Халдварт өвчин судлал	28
22.	Хүүхэд судлал	65
23.	Чих, хамар, хоолой судлал	37
24.	Эмнэл зүйн эмгэг судлал	22
25.	Эрчимт эмчилгээ судлал	27
26.	Эх барих эмэгтэйчүүд судлал	72
27.	Яаралтай тусламж судлал	21
28.	Сэргээн засал судлал	13
29.	Зүү эмчилгээ судлал	43
30.	Монголын уламжлалт анагаах ухаан судлал	15
НИЙТ ДҮН		1006